



MNAS AC07

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, ЗГ-ын II байр

Улаанбаатар 15160, Монгол Улс

Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn

Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
20.01.2021

ӨӨРЧЛӨЛТ NO: 01
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 02.12.2024

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч менежментийн тогтолцоо (тухайлбал, ЧМТ, БОМТ, ХАБМТ гэх мэт)-ны баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгон ажиллаж байгаа билээ.

MNAS нь зарим менежментийн тогтолцооны итгэмжлэлийн шалгуур, холбогдох арга зүйн зааврыг аль хэдийнээ гаргасан билээ. Энэхүү баримт бичиг нь ISO 45001 стандарт эсхүл баталгаажуулалтын хүрээнд итгэмжлэлийн схемийг хүлээн зөвшөөрөх MNAS-ийн бодлогын шаардлагад нийцсэн бусад стандартад суурилсан Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт гүйцэтгэх баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуурыг тодорхойлно. Энэ нь Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилготой. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ХЭМАБМТ)-ны баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас ХЭМАБМТ-ны баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021 “Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлага” стандартад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- ISO/IEC 17021 стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

Тайлбар: ISO/IEC 17021 стандартад өөрчлөлт орох бүрт MNAS нь IAF-аас тогтоосон шилжилтийн бодлогыг баримталдаг.

3 ISO/IEC 17021 стандартын шаардлагын удирдамж

MNAS нь ISO/IEC 17021 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашигладаг. ХЭМАБМТ-ны баталгаажуулалтын байгууллагууд нь ISO 45001:2018 стандартыг хэрэглэхдээ IAF MD 22 баримт бичгийг баталгаажуулалтыг нэмэлт шалгуур болгон ашиглах шаардлагатай.

ISO 45001:2018 стандартаас давсан нэмэлт тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC07	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 20.01.2021	Өөрчлөлт No:01	Хуудас: 1/3
	Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

4 Итгэмжлэлийн хүрээ

MNAS нь ХЭМАБМТ-ны итгэмжлэлийн хүрээг IAF-ын мэдээллийн баримт бичиг (IAF ID 1)-т заасан “Эдийн засгийн үйл ажиллагааны статистикийн нэршил”-д үндэслэн тогтоосон болно.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-ийн итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага техникийн тодорхой хүрээнд ISO 45001 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг хийх чадвартайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлүүлэх техникийн хүрээгээ тодорхойлж, тухайн хүрээнд баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах чадвартайгаа батлах үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлүүлэхийг хүссэн техникийн хүрээ, үйл ажиллагаандаа шаардлагатай ур чадвар, чадавхийг ISO/IEC 17021 шалгуур баримт бичгийн дагуу тодорхойлно.

Баталгаажуулалтын байгууллага нь аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 17021 болон ISO 19011 (хэрэв байгаа бол, IAF-ын заавал мөрдөх баримт бичиг)-т үндэслэсэн журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой хүрээнд аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

Тайлбар: Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-10 стандартын А хавсралтад заасан аудиторууд, шинжээчид болон шийдвэр гаргагчдын ур чадварыг харуулна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

Баталгаажуулалтын байгууллага нь анхдагч баталгаажуулалт, магадлах хяналт, давтан баталгаажуулалт хийхэд шаардлагатай аудитын хүн өдрийг тодорхойлох журамтай байна. Уг журамд олон салбартай байгууллагад (multisite organisations) аудит хийх хугацааг тооцоолох, баталгаажуулалтыг шилжүүлэх тухай заалтуудыг оруулна.

Баталгаажуулалтын байгууллага нь ISO 45001 стандартын аудитыг хийхдээ шаардлагатай буюу IAF-ийн заавал мөрдөх баримт бичиг, тухайлбал IAF MD 5 болон IAF MD 22-ын G 9.1.4 зэрэгт заасан дундаж хүн өдрийг ашиглана.

---xxx---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC07	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 20.01.2021	Өөрчлөлт No:01	Хуудас: 2/3
	Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлт No.	Огноо	Баталсан	Гарсан өөрчлөлт
01	2024.12.02	MNAS дарга	Дахин хянаж, шинэчлэх зорилгоор жижиг өөрчлөлтүүд хийв.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC07	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 20.01.2021	Өөрчлөлт No:01	Хуудас: 3/3
	Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ